



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/37

Даланзадгад сум

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр
олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, 6.1 дүгээр зүйл, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17, 19.18 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн удирдлагын багийн хурлаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгосон болон тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэхээр шийдвэрлэсэн эрүүл мэндийн байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан байгууллагуудын тусламж үйлчилгээнд мэргэжил арга зүй удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтэс (Б.Батболд), Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтэс (Б.Ганшагай), Хяналт шалгалтын хэлтэс (Б.Оюунсүрэн) нарт тус тус даалгасугай.

3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг холбогдох стандарт дүрэм журмын хүрээнд үзүүлж, өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж, тайлагнаж ажиллахыг эрүүл мэндийн байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Б.Цагаанцэнд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЖАВЗАНДУЛАМ

462501217

مجلس تصویب کے لئے رائے دینے والے ممبرانہ۔ ممبرانہ کے لئے
مجلس تصویب کے لئے رائے دینے والے ممبرانہ کے لئے

[illegible][illegible][illegible][illegible][illegible]

.. 96-97 (96-97) 96-97

ॐ नमो भगवते वासुदेवाय



Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн
А/37... дугаар тушаалын хавсралт

Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрлийг шинээр олгосон, тусгай зөвшөөрлийн
хугацааг сунгасан эрүүл мэндийн байгууллага

Д/д	Байгууллагын нэр, тусгай зөвшөөрлийн дугаар	Аж ахуй нэгжийн ТТД	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа	Хаяг байршил
1. Тусгай зөвшөөрлийг шинээр олгосон					
1	Талын товон ХХК Жаргал мед эмнэлэг	3666077	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ (Дотрын өвчний үзлэг оношилгоо, эмчилгээ)	2028 оны 06 сарын 25-ны өдөр хүртэл	Даланзадгад сум. 7-р баг Оюут 7-р гудамж 11 тоот
2. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгасан					
1	Говийн од дэвших ХХК – Мичид эмнэлэг ЭХ-11/14/58	5107148	шүдний үзлэг эмчилгээ	2025 оны 07 сарын 20-ны өдөр хүртэл	Цогтцэций сум Шинэ хотхон 6-1 тоот
2	Нандинзаяа ХХК Нандинзаяа эмнэлэг ЭХ14/14/75	8124175	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ (Дотрын өвчний үзлэг оношилгоо, эмчилгээ)	2030 оны 06 сарын 13-ны өдөр хүртэл	Цогтцэций сум Цагаан-Овоо баг Ямаа хүрэнгийн 9-903 тоот
3	Говийн мэлмий ХХК Говийн мэлмий эмнэлэг ЭХ-13/14/72	3619826	Нүдний эмнэлгийн тусламж үйлчилгээ	2030 оны 08 сарын 21-ны өдөр хүртэл	Даланзадгад сум 3-р баг БОЭТ-н дэргэд
3.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн					
1	Баянзаараг ХХК Оточ эмнэлэг ЭХ-15/14/73	3615731	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ (сэргээн засах, уламжлалт тусламж үйлчилгээ)	Түдгэлзүүлсэн	Цогтцэций сум Цагаан-Овоо баг, Бумбан овоо 1-2 тоот
2	Тэсийн хийморь ХХК Хан-од эмнэлэг ЭХ-22/14/133	3647153	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ (уламжлалтын тусламж үйлчилгээ)	Түдгэлзүүлсэн	Гурвантэс сум Урт баг